



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/256.

Улаанбаатар хот

Ангилал шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар батлагдсан "Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд тавих шаардлага, загвар"-ын 2.10 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/144 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Архангай аймаг дахь "Гурван тамир" Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг политехник коллежийн ангилалд шилжүүлсүгэй.

2.Ангилал шинэчлэн тогтоосонтой холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын дагуу үйл ажиллагааг зохион байгуулах, улсын бүртгэл, харьяа аймгийн татварын хэлтэст бүртгүүлэхийг Архангай аймаг дахь "Гурван тамир" Политехник коллежийн захирал /С. Нямгэрэл/-д үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрөл болон хавсралтад шинэчлэн бичилт хийх, энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-Шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Ч. Энх-Амгалан/-т даалгасугай.

САЙД



Л. ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН

142210923

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны 07 сарын 06 өдрийн А/256
дугаар тушаалын хавсралт

СУРГАЛТ ЭРХЛЭХ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ

№	Сургалтын байгууллага	Мэргэжлийн нэр	Индекс		Сургалтын хугацаа /жил/
1	Архангай аймаг дахь "Гурвантамир" Политехник коллеж	Малын бага эмч	АН	3240-17	1.5
		Малын бага эмч	АН	3240-17	3
		Зоотехникч	АН	3240-16	1.5
		Зоотехникч	АН	3240-16	3